

“ЭРЧИМ ХҮЧ-3 ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГАА

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийсэн.

I. Асуудалд дүн шинжилгээ хийх

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.2.35-д “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна” гэж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын Эрчим хүчний сэргэлтийн 9-д “Багануур-Чойр эрчим хүчний дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний төсөл” гэж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.29-д “Багануур-Чойр чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төслийн бэлтгэл ажлыг хангана” арга хэмжээ тусгагдсаныг хэрэгжүүлэхэд хуулийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

2. “Багануур-Чойр-Айраг-Сайншанд-Замын-Үүд” болон “Багануур-Улаанбаатар” чиглэлийн 110кВ-ын 1 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/-аар дамжуулан эрчим хүчний хэрэглээг Дорноговь, Дундговь, Хэнтий, Өмнөговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад хангаж байна. Энэ нь болзошгүй цахилгаан дамжуулах агаарын шугамын гэмтэл, саатал гарсан үед дээр дурдсан аймгуудын 70,740 айл өрх, 46,261 аж ахуй нэгжийн цахилгаан эрчим хүч тасалдах эрсдэл үүссэн асуудлыг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

3. Уул уурхай, барилгын материалын үйлдвэрлэлтэй холбоотой төслүүд Монгол Улсын говь болон зүүн урагшаа чиглэлд эрчимтэй хөгжиж байна. Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт байрлах Газрын тос боловсруулах үйлдвэр, цементийн үйлдвэрлэл, жоншны уурхай Цагаансуварга, Тавантолгой, Оюутолгойн зэс, нүүрсний уурхай, Замын-Үүдийн чөлөөт бүс зэрэг нь 416-900 хүртэл мВт чадал хэрэглэнэ. Энэхүү чадал, ачааллын урсгалыг өнөөгийн 207-р ЦДАШ-аар дамжуулах боломжгүй. 207-р ЦДАШ-ын дамжуулах чадвар хүрэлцэхгүй бөгөөд шугамын төгсгөлд хүчдэл түвшин эрс буурч чанар стандартын шаардлага хангадаггүй. Жишээ нь 207-р ЦДАШ-аас тэжээгддэг Чойр дэд станцаас гарсан Бор-Өндөр, Өндөрхаан дэд станцад $U=100/34/5.8$ кВ болж нэгдсэн сүлжээний дүрэмд заасан чанарын шаардлага хангадаггүй бөгөөд хэрэглэгч талд гэр ахуйн цахилгаан тоноглол хэвийн ажилладаггүй, гэмтдэг зөрчил доголдлууд их гардаг тул үүссэн асуудлыг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

II. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох

Асуудлыг шийдвэрлэх зорилтыг “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж тодорхойлж байна.

III. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэсэн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд зохицуулалтын дараах хувилбаруудыг сонгон тодорхойлж байна:

- Захиргааны шийдвэр гаргах;
- Хуулийн төсөл боловсруулах;

Сонгосон хувилбаруудын зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцааны эерэг, сөрөг талыг харьцуулан судалбал:

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
Захиргааны шийдвэр гаргах	<p>Захиргааны ерөнхий хуулийн 11, 12 дугаар зүйлүүдэд захиргааны шийдвэр гаргах ажиллагааг захиргааны акт, захиргааны гэрээтэй холбогдсон үйл ажиллагаа гэж тайлбарласан.</p> <p>Улмаар мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж, 52 дугаар зүйлийн 52.1-д “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.” гэж тус тус заасан.</p> <p>Хуулийн дээрх тодорхойлолтуудыг харвал тулгамдаад байгаа асуудлуудыг захиргааны шийдвэр буюу захиргааны акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар шийдвэрлэх боломжгүй байна.</p>	
Хуулийн төсөл боловсруулах	<p>Өөрчлөхөөр тулгамдаж байгаа асуудлуудын зарим нь одоо хуулиар зохицуулагдаж байгаа, мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тус тус заасны</p>	<p>Хуулийн төсөлтэй холбогдуулан 19.4 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарна.</p>

	дагуу хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэхээр байна.	
--	--	--

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэсэн зорилгыг хангахад захиргааны шийдвэр гаргах, хуулийн төсөл боловсруулах гэсэн зохицуулалтын хувилбаруудыг дэвшүүлж, зорилгод хүрэх байдал, эерэг, сөрөг талуудыг харьцуулан судалж, мөн хуульд нийцсэн байх зарчмын дагуу хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбарыг оновчтой хувилбар гэж сонгож байна.

IV. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах

Аргачлалд заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтүүдээр тандан судалж байна:

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	хамааралгүй
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй	хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

Хүснэгт 2

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр		Хариулт	Тайлбар
------------	--	---------	---------

нөлөө	Холбогдох асуулт			
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	хамааралгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
4.Мэдээлэх үүргийн улмаас	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	

үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	(Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх			
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	

9.Төрийн захиргааны байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм <input checked="" type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	

Хүснэгт 3

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	хамааралгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input checked="" type="checkbox"/>	

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
4.Төрийн удирдлага, засаглал, эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input type="checkbox"/>	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	хамааралгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй <input checked="" type="checkbox"/>	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	хамааралгүй

V. Дүгнэлт

Дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох гэсэн зорилгыг хангахаар захиргааны шийдвэр гаргах, хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбаруудыг дэвшүүлж, хувилбаруудын зорилгод хүрэх байдал, эерэг, сөрөг талуудыг харьцуулан судалж, хуулийн төсөл боловсруулах гэсэн хувилбарыг оновчтой хувилбар гэж сонгож байна.

Энэхүү хувилбарын хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тандан судалснаас хамааралтай үзүүлэлтүүдэд эерэг хариулттай байна.

VI. Зөвлөмж

Төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлогын хүрээнд “Оюутолгой” уурхайг цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний Монгол Улсын эрчим хүчний салбарын хариуцах хэсэгт техникийн найдвартай ажиллагааг хангахын тулд 207 дугаар цахилгаан дамжуулах агаарын шугамыг 2 хэлхээ болгох шаардлагатай бөгөөд ба уг шугамаар Оюутолгой уурхайг хангах нэг талын тэжээл болох юм. Үүний үр дүнд жил бүр 100-120 сая ам.доллар Оюутолгой уурхайг ЦЭХ-ээр тэжээхэд БНХАУ-д төлж буй мөнгөн урсгал, валют дотооддоо үлдэх боломж бүрдэх юм.
2. Говийн бүсэд баригдсан Цэций /50 МВт/, Сайншанд /55 МВт/ салхин цахилгаан станц, Нарантээг /15 МВт/, Говь /30 МВт/, Сүмбэр /10 мВт/ нарны станцууд өнөөгийн нэг хэлхээт 220 болон 110 кВ-ын ЦДАШ-ын улмаас бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжгүй байгаа бөгөөд 207-р ЦДАШ давхар хэлхээтэй болсноор бүрэн хүчин чадлаараа ажиллаж байгальд орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл 30-50 хувь өсөх боломж бүрдүүлэхээр байна.
3. Чойр-Сайншанд-Замын-үүд 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадвар хүрэлцэхгүй байгаагаас шалтгаалан чадлын урсгалыг 50 МВт-аас дээш чадал дамжсан нөхцөлд сэргээгдэх эрчим хүчний байгальд орчинд ээлтэй үйлдвэрлэлийг шугамын дамжуулах чадвараас шалтгаалж, хориглож байна.

Иймээс “Алсын хараа-2050” Монгол Улсын хугацааны хөгжлийн бодлого болон бусад дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулахад уг төслийг хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

---oO---